

НОГООН АЛТ, МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД ТӨСЛИЙН НЭГДСЭН ҮЕ ШАТ

БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:

Ногоон алт, малын эрүүл мэнд
төслийн нэгдсэн үе шат

Хугацаа:

2017-2020

Төсөв:

7.0 сая шв.франк

Зорилтот бүлэг:

- 80,000 малчин өрх
- 100 малчдын хоршоо
- Бэлчээр ашиглагчдын холбоо, малчдын хоршооны 1800 гаруй удирдах ажилтан
- Малчдын дундын сангийн гишүүн 18000 малчин өрх
- 7000 төрийн албан хаагчид болон аймаг, сумын иргэдийн хурлын төлөөлөгчид



Архангай аймгийн Ихтамир сумын Хужир улаалзай БАХ-ийн гишүүн П. Батболдын хотонд мал төллөх цагаар.

ҮНДЭСЛЭЛ

Малын тэжээлийн үндсэн эх үүсвэр болсон бэлчээр нутаг Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 80 хувийг эзэлдэг. Эрдэмтдийн хийсэн судалгааны дүнгээс үзэхэд бэлчээр нутгийн 65 хувийн унаган төрх өөрчлөгдөж доройтолд өртжээ. Энэ нөхцөл байдал Монгол улсын мал аж ахуйн үйлдвэрлэл,

малчдын амьжиргааны тогтвортой, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Иймд, бэлчээр нутгаа зохистой ашиглах, талхагдлыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодитой үйл ажиллагаануудыг яаралтай хэрэгжүүлэх цаг тулж ирсэн байна.

ЗОРИЛГО

Бэлчээрийн тогтвортой менежмент, малын гаралтай бүтээгдэхүүний маркетинг, малын эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр гарсан үр дүн, амжилтуудыг өргөжүүлэн нэвтрүүлэхэд оршино.

ӨМНӨХ ҮЕ ШАТНЫ ҮР ДҮНГЭЭС:

Экологийн чадавхид суурилсан, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бэлчээрийн төлөв байдлыг хянах үнэлгээний системийг (схем 1) Засгийн газрын мэргэжлийн байгууллага, агентлагуудтай хамтран нэвтрүүллээ. Энэхүү шинэ аргачлалыг орон нутгийн төвшинд 7 аймагт хэрэгжүүлж байна.

Ногоон алт төслийн дэмжлэгээр малчдын бэлчээр ашиглагчдын 1300 хэсгүүдэд (БАХ) тулгуурласан 35,000 малчин өрхийн гишүүнчлэл бүхий сум, аймгийн Бэлчээр ашиглагчдын холбоодыг нэгтгэсэн Үндэсний бэлчээр ашиглагчдын холбоо байгуулагдлаа.

Бэлчээрийн сэргэх чадавхид суурилсан ашиглалт



Схем 1

ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

